



ХЭНТИЙ АЙМАГ
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 5/16

Бэрх

08 дугаар сарын ур чадварын
нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, “Төрийн албаны тухай” хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Захирагчийн ажлын албаны даргын 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/20 дугаар “Захирагчийн ажлын албаны үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо биелүүлж, идэвх санаачилгатай ажилласан төрийн үйлчилгээний албан хаагчдын 2024 оны 08 дугаар сарын ур чадварын нэмэгдлийн хувь, нэрсийг хавсралтаар баталсугай.

2. 2024 оны 08 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 08 дугаар сарын цалин дээр холбогдох хууль, журмын дагуу бодож олгохыг Нягтлан бодогч /Г.Осгонжаргал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.МЯГМАРСҮРЭН

E.blank/Тушаал Б/